



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Монгол Улсын Шадар сайд /Гадаадын хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаа хариуцсан/-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/13/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаанбаатар хот
2026 он

Тусгай чиг үүргийн аудитын газрын
захирал, тэргүүлэх аудитор: Д.Баярсайхан
Утас: 261663 Цахим хаяг: bayarsaikhand@audit.gov.mn
Аудитын менежер: С.Нацагдорж
Утас: 260512 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn
Ахлах аудитор: Э.Бат-Эрдэнэ
Утас: 261729 Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn
Аудитор: Б.Батхишиг
Утас: 261729 Цахим хаяг: batkhishigb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	7
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	7
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
3.1 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний эрхлэх асуудал	11
3.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
4. АУДИТЫН ТАЙЛАН	20
4.1 Ерөнхий зүйл.....	20
4.2 Материаллаг байдал	20
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	20
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	21
4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	24
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	24
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	25
5.1 Харьяа байгууллагууд	25
5.2 Төсвийн ерөнхийлөн захирагч	25
5.3 Түүвэрт хамрагдсан байгууллага	27
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	30

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
МУДШ	Монгол Улсын Дээд Шүүх
МУЗГ	Монгол Улсын Засгийн Газар
МЭГ	Монополын эсрэг газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт Бичиг
НТШ	Нээлттэй сонгон шалгаруулалт
САГ	Санхүүгийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЕЗ	Төсвийн Ерөнхийлөн Захирагч
ТХААГ	Төрийн худалдан авах ажиллагааны газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХХА	Худалдан авах ажиллагаа
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД
Т.ДОРЖХАНД ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

Засгийн газрын IV байр, Бага тойруу-3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26-04-37, Факс: (976-51) 26 42 30
Цахим шуудан: info@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.04.27 № 1144
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Монгол Улсын Шадар сайд /Гадаадын хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаа хариуцсан/-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 231.8 сая төгрөгийн зөрчил илэрч бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Монополын эсрэг газар нь тайлант онд судалгааны ажил гүйцэтгүүлэхдээ төсвийн нарийвчилсан тооцоо, өртгийн судалгаа хийлгүйгээр гэрээний үнийг 500.0 сая төгрөгөөр тогтоосон, гэрээнд заасан судалгааны ажлаас 2 ажлыг хийгээгүй, бусад судалгааны ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгээгүй байхад урьдчилгаа төлбөрт 150.0 сая төгрөгийг шилжүүлж гэрээний гүйцэтгэлийг хаасан;
- Монополын эсрэг газар нь гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт гаргаагүй, газар, хэлтсийн дарга нар албан хаагчдын улирлын ажлын үр дүнг үнэлж дүгнээгүй байхад нийт 43.2 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон;

- Төрийн худалдан авах ажиллагааны газрын үйлчилгээний хураамжийн орлогын бүртгэл, хяналт, тайлагналын тогтолцоо хангалтгүй, нягтлан бодох бүртгэлээр тавих хяналт хангалтгүй;
- Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагууд төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан даруйд олон нийтэд мэдээлээгүй, сонгон шалгаруулалт явуулах тухай захиалгыг холбогдох байгууллагад хүргүүлэлгүйгээр сул орон тоонд тусгай шалгалт өгөөгүй нийт 9 албан хаагчийг түр орлон гүйцэтгэгчээр томилсон зэрэг нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 5.1.5, 6 дугаар зүйлийн 6.4.1, 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.10, 14.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 14.4.2 дахь заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Хөрөнгө оруулалт, худалдааны газар нь 2025 онд эдийн засгийг төрөлжүүлэх, үндэсний үйлдвэрлэгчдийг гадаад зах зээлтэй холбох, хөрөнгө оруулалт татах зорилгын хүрээнд Харбины олон улсын эдийн засаг, худалдааны 34 дэх удаагийн үзэсгэлэнд ноос, ноолууран болон арьс ширэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч аж ахуй нэгжүүдийг оролцуулсан нь олон улсын зах зээлд бүтээгдэхүүнээ сурталчлах, борлуулалтыг нэмэгдүүлэх, түншлэлээ өргөжүүлэх боломжийг бүрдүүлсэн байна.

Тайлант онд Монополын эсрэг газар нь бүх төрлийн шатахуун импортлох болон бөөний, жижиглэнгийн худалдаа эрхэлж буй аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж АИ 92 шатахууны үнийг хэлцэн тогтоосон 11 аж ахуй нэгжид 48,490.9 сая төгрөг, үнийг хэлцэн тогтооход дэмжиж оролцсон 10 аж ахуйн нэгжид 4,151.1 сая төгрөгийн торгуулийг тус тус ногдуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд Төрийн худалдан авах ажиллагааны газар нь нийт 1,889,500.0 сая төгрөгийн өртөг бүхий 87 төсөл, арга хэмжээний 497 багц ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулснаас 494 багцын тендерийн урилгыг цахим худалдан авах ажиллагааны системд нийтэлж, тендерийн материалыг цахимаар хүлээн авч, худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагууд тайлант онд бараа, ажил, үйлчилгээг санхүүжилтийн эх үүсвэр, нэр төрөл, тендер шалгаруулалтын арга, төсөл, арга хэмжээ нэг бүрээр тусгаагүй бөөн дүнгээр нэгтгэж төлөвлөсөн, зарим төсөл, арга хэмжээг төлөвлөгөөнд тусгалгүйгээр худалдан авсан байна.

Мөн бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, өртгийн тооцоог нарийвчлан боловсруулахгүйгээр ерөнхий байдлаар боловсруулж байна.

Бусад асуудлын хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны “Засгийн газрын агентлагийн бүтэц, орон тооны талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 52 дугар тогтоол, Монгол Улсын Шадар сайдын 2025 оны “Стратеги, зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн батлах тухай” 53 дугаар тушаалаар харьяа байгууллагуудын бүтцийг шинэчлэн баталсан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад асуудлын хэсгийг хамраагүй болно.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд Аудитын олон улсын стандартын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



С.МАГНАЙСҮРЭН

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	36,018.3	531,494.7
33	АВЛАГА	960.2	316,580.8
34	УРЬДЧИЛГАА	939.5	158,100.0
35	БАРАА МАТЕРИАЛ	34,118.6	56,814.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,843,545.0	3,316,622.5
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,843,545.0	3,316,622.5
39200	Биет хөрөнгө	1,365,245.2	853,270.5
39300	Биет бус хөрөнгө	2,478,299.8	2,463,352.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	3,879,563.3	3,848,117.2
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	672.0	130,188.6
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	672.0	130,188.6
41300	Өглөг	672.0	130,188.6
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,878,891.3	3,717,928.7
51	Засгийн газрын хувь оролцоо	3,878,891.3	3,717,928.7
51200	Хуримтлагдсан үр дүн	3,878,891.3	3,717,928.7
51210	Өмнөх үеийн үр дүн	-	3,883,891.3
51220	Тайлант үеийн үр дүн	3,878,891.3	(165,962.6)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	3,879,563.3	3,848,117.2

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	9,985,175.9	6,705,604.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,033,044.1	6,705,604.8
120	Нийтлэг татварын бус орлого	4,033,044.1	563,662.3
122	Тусламжийн орлого	-	6,141,942.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,952,131.8	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	6,077,039.7	6,852,830.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,077,039.7	6,852,830.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,795,925.9	5,841,132.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,883,445.7	3,438,178.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	375,863.0	442,865.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	256,617.4	414,563.9
2104	Хангамж, бараа материалын зардал	140,036.0	171,391.4
2105	Норматив зардал	2,427.3	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,600.5	88,224.5
2107	Томилолт, зочны зардал	34,784.2	33,262.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	684,213.9	669,159.9

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	404,937.9	583,486.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,281,113.7	1,011,698.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	3,908,136.2	(147,226.0)
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	29,244.9	18,736.6
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	(29,244.9)	(18,736.6)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	3,878,891.3	(165,962.6)

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-
9	Тайлант үеийн үр дүн	3,878,891.3	3,878,891.3
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,878,891.3	3,878,891.3
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	5,000.0	5,000.0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,883,891.3	3,883,891.3
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-
19	Тайлант үеийн үр дүн	(165,962.6)	(165,962.6)
20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,717,928.7	3,717,928.7

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	5,977,268.9	6,652,925.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	25,137.1	6,652,925.7
120	Нийтлэг татварын бус орлого	25,137.1	510,983.3
122	Тусламжийн орлого	-	6,141,942.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,952,131.8	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,669,150.6	6,648,925.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,669,150.6	6,648,925.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,387,453.8	5,336,363.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,875,131.2	3,437,067.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	378,535.6	444,234.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	256,617.4	313,345.0
2104	Хангамж, бараа материалын зардал	91,966.9	126,953.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,541.8	125,739.0
2107	Томиллолт, зочны зардал	31,784.2	37,532.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	727,977.7	831,828.3

Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,899.0	19,664.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,281,696.7	1,312,561.9
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	308,118.3	4,000.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	308,118.3	4,000.0
2200	Дотоод эх үүсвэрээр	308,118.3	4,000.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(308,118.3)	(4,000.0)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	6,267,430,500.00	5,725,502,121.76	541,928,378.24	91.4
12	Татварын бус орлого	6,267,430,500.00	5,725,502,121.76	541,928,378.24	91.4
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,267,430,500.00	5,330,418,845.10	937,011,654.90	85.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,267,430,500.00	5,330,418,845.10	937,011,654.90	85.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,238,634,000.00	5,303,722,345.10	934,911,654.90	85.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,803,346,800.00	3,437,067,116.46	366,279,683.54	90.4
210101	Үндсэн цалин	2,245,918,100.00	1,943,953,651.53	301,964,448.47	86.6
210102	Нэмэгдэл	899,087,700.00	666,605,514.04	232,482,185.96	74.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	390,336,100.00	548,129,765.30	(157,793,665.30)	140.4
210104	Урамшуулал	268,004,900.00	278,378,185.59	(10,373,285.59)	103.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	488,668,800.00	444,234,726.88	44,434,073.12	90.9
210201	Тэтгэврийн даатгал	332,374,000.00	306,387,719.27	25,986,280.73	92.2
210202	Тэтгэмжийн даатгал	39,088,500.00	34,941,643.47	4,146,856.53	89.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	19,553,100.00	17,652,229.13	1,900,870.87	90.3
210204	Ажилгүйдлийн даатгал	19,531,100.00	17,052,716.91	2,478,383.09	87.3
210205	Эрүүл мэндийн даатгал	78,122,100.00	68,200,418.10	9,921,681.90	87.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	322,745,800.00	313,345,000.00	9,400,800.00	97.1
210301	Гэрэл, цахилгаан	266,800.00	-	266,800.00	0.0
210304	Байрны түрээс	322,479,000.00	313,345,000.00	9,134,000.00	97.2
2104	Хангамж, бараа материалын зардал	187,886,500.00	126,952,956.76	60,933,543.24	67.6
210401	Бичиг хэрэг	52,989,600.00	34,501,250.86	18,488,349.14	65.1
210402	Тээвэр, шатахуун	25,025,000.00	18,245,480.00	6,779,520.00	72.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	87,077,600.00	59,509,578.90	27,568,021.10	68.3
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	22,794,300.00	14,696,647.00	8,097,653.00	64.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	127,883,900.00	125,738,984.00	2,144,916.00	98.3
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,136,200.00	18,251,730.00	(12,115,530.00)	297.4
210604	Урсгал засвар	121,747,700.00	107,487,254.00	14,260,446.00	88.3
2107	Томилолт, зочны зардал	27,982,300.00	27,702,271.00	280,029.00	99.0
210701	Гадаад албан томилолт	16,792,400.00	16,792,371.00	29.00	100.0
210702	Дотоод албан томилолт	11,189,900.00	10,909,900.00	280,000.00	97.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,260,455,900.00	809,017,290.00	451,438,610.00	64.2

Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,118,063,800.00	669,138,258.00	448,925,542.00	59.8
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	411,600.00	-	411,600.00	0.0
210803	Даатгалын үйлчилгээ	18,651,600.00	18,313,090.00	338,510.00	98.2
210804	Тээврийн хэрэгслийн татвар	779,600.00	493,256.00	286,344.00	63.3
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	70,200.00	22,000.00	48,200.00	31.3
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	122,079,600.00	120,755,732.00	1,323,868.00	98.9
210807	Газрын төлбөр	399,500.00	294,954.00	104,546.00	73.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,664,000.00	19,664,000.00	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	19,664,000.00	19,664,000.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,796,500.00	26,696,500.00	2,100,000.00	92.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,796,500.00	26,696,500.00	2,100,000.00	92.7
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	17,996,500.00	17,696,500.00	300,000.00	98.3
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,800,000.00	9,000,000.00	1,800,000.00	83.3
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	395,083,276.66	(395,083,276.66)	-
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	(395,083,276.66)	395,083,276.66	-
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	(395,083,276.66)	395,083,276.66	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	3	3	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	109	99	10	90.8
620001	Удирдах ажилтан	9	5	4	55.6
620002	Гүйцэтгэх ажилтан	93	84	9	90.3
620003	Үйлчлэх ажилтан	7	10	(3)	142.9

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	-	439,336,641.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	439,336,641.50
122	Тусламжийн орлого	-	439,336,641.50
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	36,641,480.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	36,641,480.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	36,641,480.00
2107	Томилолт, зочны зардал	-	9,830,480.00
210702	Дотоод албан томилолт	-	9,830,480.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	26,811,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	26,811,000.00
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	402,695,161.50
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	(402,695,161.50)
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	(402,695,161.50)

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний эрхлэх асуудал

Монгол Улсын Шадар сайд эрхэм зорилгоо “Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэн хөрөнгө оруулалтыг татах, дэмжих, хөрөнгийн урсгалыг тогтворжуулах, худалдааны эргэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн цогц үйл ажиллагааг зохион байгуулах замаар эдийн засгийг төрөлжүүлэн хөгжүүлж тогтвортой өсөлтийг хангах, худалдан авах ажиллагааг ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай зохион байгуулж, төрийн худалдан авах ажиллагааг олон улсын жишигт хүргэх, концесс, төр хувийн хэвшлийн түншлэлийн бодлогыг зөв зохистой төлөвлөж, нийгмийн суурь үйлчилгээг нийтэд үзүүлэх, Монгол Улсын зах зээлд чөлөөт өрсөлдөөний таатай орчин бүрдүүлж, шударга нээлттэй зах зээлийг бий болгох, хэрэглэгчийн сайн сайхан байдлыг дээшлүүлэхэд оршино” гэж тодорхойлсон байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч дараах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг цахим системээр дамжуулан улсын хэмжээнд нэгтгэн зохион байгуулах;
- Байнгын хэрэгцээт бараа, үйлчилгээг ерөнхий гэрээгээр дамжуулан худалдан авах ажиллагааг улсын хэмжээнд нэгдсэн байдлаар зохион байгуулах, ерөнхий гэрээний хэрэгжилтэд хяналт тавих;
- Худалдан авах ажиллагааг шуурхай, ил тод болгох, тендер шалгаруулалтын үнэлгээнд хүний оролцоог бууруулах, техник технологийн бэлэн байдлыг хангах, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих асуудалд төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодтой хамтран ажиллах, санал боловсруулах;
- Дотоодод үйлдвэрлэсэн, чанар стандартын шаардлага хангасан бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэгч дотоодын аж ахуйн нэгж, үндэсний үйлдвэрлэгчдийн бараа, бүтээгдэхүүнийг худалдан авах, эх оронч худалдан авах ажиллагааг зохион байгуулах;
- Гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын хууль тогтоомж, нэгдсэн бодлогыг тодорхойлох, боловсруулах, зохицуулалтаар хангахад дэмжлэг үзүүлэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад ээлтэй эрх зүйн орчин бүрдүүлэх;
- Хөрөнгө оруулалт, худалдааны үйл явцыг хөнгөвчлөх, экспортын болон импортын үйл ажиллагаатай холбоотой зохицуулалтыг оновчтой болгох, хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгчдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх, бүртгэлийн системийг сайжруулах, цахим платформоор дамжуулан хөрөнгө оруулагчид болон бизнес эрхлэгчдийг хялбар, шуурхай бүртгэх, гомдол, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх;
- Монгол улсад аж ахуй эрхлэгчдийн зах зээлд шударгаар өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, түүнд ноёлох болон харш аливаа үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, хориглон хязгаарлах, өрсөлдөөнийг зохицуулах замаар хэрэглэгчийг чанартай бараа, ажил үйлчилгээгээр хангах, тэдний эрхийг хамгаалах.

3.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн гадаад, дотоод орчин

Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хөрөнгө оруулалтын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Зөрчлийн тухай хууль, Концессын тухай хууль, Олон улсын гэрээний тухай хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийг мөрдөн ажиллаж байна. Тайлант хугацаанд Төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын тухай хууль-нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- Хөрөнгө оруулалтын тухай хууль - өөрчлөлт оруулах тухай;
- Төсвийн тухай хууль - нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- Төрийн албаны тухай хууль- нэмэлт оруулах тухай;
- Захиргааны ерөнхий хууль-нэмэлт оруулах тухай;
- Засгийн газрын 2025 оны “Томилолтын зардлыг шинэчлэн тогтоох тухай” 133 дугаар тогтоол;
- Сангийн сайдын 2025 оны “Төсвийн зарим ангилал шинэчлэн батлах тухай” 112 дугаар тушаал;
- Засгийн газрын 2025 оны “Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн батлах тухай” 21 дүгээр тогтоол;
- Төрийн худалдан авах ажиллагааны газрын даргын 2025 оны “Албан тушаалын жагсаалт, орон тоог шинэчлэн батлах тухай” А/55 дугаар тушаал;

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд тус бүр Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй бөгөөд батлагдсан хугацаанаас хойш шинээр батлагдсан стандарт, хууль, журмын заалт, холбогдох өөрчлөлтийг тусгаагүй шинэчлэн найруулаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 31.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	1.0	316.6	315.6
Урьдчилгаа	0.9	158.1	157.2
Бараа материал	34.1	56.8	22.7
Үндсэн хөрөнгө	3,843.5	3,316.6	(526.9)
Нийт хөрөнгө	3,879.6	3,848.1	(31.4)
Өр төлбөр	0.7	130.2	129.5
Засгийн газрын хувь оролцоо	3,878.9	3,717.9	(161.0)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,879.6	3,848.1	(31.4)

Эх сурвалж: Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Дээрх хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан авлага, урьдчилгаа, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо зэрэг дансдууд байна.

Харьяа байгууллага /Монополын эсрэг газар/

Аудитын илрүүлэлт:

1. Төсөв захирагч нь албан хаагчдын цалинг тооцохдоо тайлант онд дотоод албан томилолтоор явсан 18 албан хаагчдад 2.9 сая төгрөгийн хоол, унааны зардлыг давхардуулан тооцож олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

2. Албан хаагчид гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг гаргаагүй, газар, хэлтсийн дарга албан хаагчдын тухайн улирлын ажлын үр дүнг үнэлж дүгнээгүй байхад төсөв захирагчийн тушаалаар тайлант оны 1 дүгээр улиралд 23.4 сая төгрөгийн, 3 дугаар улиралд 19.9 сая төгрөгийн нийт 43.3 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

3.4.1 Авлага

Авлага дансны үлдэгдэл 316.5 сая төгрөг болж, өмнөх оноос 315.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт +, Бууралт (-)
Ажиллагсадтай холбогдсон авлага	1.0	0.5	(0.5)
Татаас, санхүүжилтийн авлага	-	316.0	316.0
Дүн	1.0	316.5	315.5

/сая төгрөгөөр/

Эх сурвалж: Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Авлага дансны үлдэгдэл 315.5 сая төгрөгөөр өссөн нь Төрийн худалдан авах ажиллагааны газрын 2025 оны давсан орлогоос татаас санхүүжилтийн авлага үүсгэсэнтэй холбоотой байна.

3.4.2 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны үлдэгдэл 158.1 сая төгрөг болж, өмнөх оноос 157.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Урьдчилгаа дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт +, Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	0.9	158.1	157.2
Дүн	0.9	158.1	157.2

/сая төгрөгөөр/

Эх сурвалж: Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Урьдчилгаа дансны үлдэгдэл 157.2 сая төгрөгөөр өссөн нь Монополын эсрэг газрын албан хаагчдын амь нас, эрүүл мэндийн даатгал болон судалгааны ажлын дүн голлон нөлөөлсөн байна.

Харьяа байгууллага /Монополын эсрэг газар/

Аудитын илрүүлэлт:

Монополын эсрэг газрын төсөв захирагч нь Монгол Улсын Их Сургуультай 2025 оны 8 дугаар сарын 29 ний өдөр 500.0 сая төгрөгийн үнийн дүн бүхий судалгааны ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулсан боловч гэрээнд тусгасан нийт 7 нэр, төрлийн судалгааны ажлаас 2 судалгааны ажлын даалгаврыг боловсруулаагүй, төсвийн нарийвчилсан тооцоолол, өртгийн судалгааг хийлгүйгээр гэрээний үнийг шууд тогтоосон байна. Мөн гэрээний хүчин төгөлдөр хугацаа дууссан байхад талууд гэрээг дүгнээгүй, аудит гүйцэтгэж байх хугацаанд нэмэлт гэрээ нөхөж байгуулсан, судалгааны ажлаас 2 ажлыг огт хийгээгүй байхад төсөв захирагч төлбөрийг бүрэн олгохыг үүрэг

болгосон, түүнчлэн бусад судалгааны ажлуудыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгээгүй байхад алданги тооцоогүй, гэрээнд оюуны өмчийг эзэмших, ашиглах, баталгаажуулах, хориглох нөхцөл болон талуудын хооронд тохирсон бусад асуудлын талаар тусгаагүй. Үүний улмаас хүлээн авсан 5 судалгааны ажил тус бүрийн өртөг, үнийн дүнг тодорхойлох боломжгүй байна.

3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны үлдэгдэл 56.8 сая төгрөг болж, өмнөх оноос 22.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт +, Бууралт (-)
Хангамжийн материал	34.1	52.8	18.6
Бичиг хэргийн материал	12.3	12.7	0.4
Аж ахуйн материал	13.5	25.6	12.1
Сэлбэг хэрэгсэл	0.3	1.7	1.4
Түлш, шатах тослох материал	-	0.6	0.6
Бусад хангамжийн материал	8.0	12.3	4.2
Тусгай зориулалттай материал	-	4.1	4.1
Дүн	34.1	56.8	22.7

Эх сурвалж: Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Бараа материалын дансны үлдэгдэл 22.7 сая төгрөгөөр өссөн нь Монополын эсрэг газар болон Хөрөнгө оруулалт, худалдааны газрын бараа материалын өсөлтүүд голлон нөлөөлсөн байна.

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэлд Монополын эсрэг газар 40.8 сая төгрөгийн буюу 72.0 хувь, Төрийн худалдан авах ажиллагааны газар 6.4 сая төгрөг буюу 11.3 хувь, Хөрөнгө оруулалт, худалдааны газар 9.5 сая төгрөгийн буюу 16.7 хувийг тус тус эзэлж байна.

3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 3,316.6 сая төгрөг болж, 526.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт +, Бууралт (-)
Биет хөрөнгө	1,365.2	853.3	(512.0)
Авто-тээврийн хэрэгсэл	76.0	76.0	-
Машин тоног төхөөрөмж(компьютер)	1,455.4	1,449.6	(5.8)
Тавилга, аж ахуйн эд хогшил	420.6	341.9	(78.7)
Бусад үндсэн хөрөнгө	0.2	0.2	-
Биет бус хөрөнгө	2,478.3	2,463.4	(14.9)
Программ хангамж	29.6	28.1	(1.5)
Бусад биет бус хөрөнгө	2,453.1	2,462.1	9.0
Дүн	3,843.5	3,316.6	(526.9)

Эх сурвалж: Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Төсвийн ерөнхийлөн захирагчийн үндсэн хөрөнгө дансны эцсийн 526.9 сая төгрөгөөр буурсан нь Төрийн худалдан авах ажиллагааны газарт ТӨБЗГ-ын даргын 2025 оны 301 дүгээр тогтоолын дагуу 68.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг ХХААХҮЯ-нд балансаас

балансад шилжүүлсэн, ТӨБЗГ-ын даргын 2025 оны 806 дугаар тогтоолын дагуу 33.4 сая төгрөгийн элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг дахин үнэлсэн, Монополын эсрэг газарт ТӨБЗГ-ын даргын 2025 оны А-4/2700 шийдвэрийн дагуу 40.2 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлээс хассан, харьяа байгууллагуудын үндсэн хөрөнгөд 1,041.2 сая төгрөгийн элэгдлийн зардал тооцсон зэрэг нь голлон нөлөөлсөн байна.

3.4.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны үлдэгдэл 130.2 сая төгрөг болж, өмнөх оноос 129.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт +, Бууралт (-)
Ажиллагсадтай холбоотой өглөг	0.5	-	(0.5)
Байгууллагад төлөх өглөг	0.1	111.7	111.6
Хувь хүмүүст өгөх өглөг	-	18.5	18.5
Дүн	0.6	130.2	129.6

Эх сурвалж: Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Өсөлтийн бүтцийн тухайд нийт өсөлтийн 81.7 хувийг Төрийн худалдан авах ажиллагааны газрын байр ашиглалтын зардлын төсөв хүрэлцээгүйгээс үүссэн 105.9 сая төгрөгийн өглөг, 12.7 хувийг Монополын эсрэг газрын бүтцийн өөрчлөлтөөр чөлөөлөгдсөн албан хаагчдад олгох тэтгэмжийг өгөөгүйтэй холбоотой 16.4 сая төгрөгийн өглөгүүд голлон эзэлж байна.

3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 3,717.9 сая төгрөг болж, өмнөх оноос 161.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт +, Бууралт (-)
Засгийн газрын хувь оролцоо	3,878.9	3,717.9	(161.0)
Засгийн газрын оруулсан капитал	3,878.9	3,717.9	(161.0)
Хуримтлагдсан үр дүн	3,878.9	3,717.9	(161.0)
Өмнөх үеийн үр дүн	-	3,883.9	3,883.9
Тайлант үеийн үр дүн	3,878.9	(166.0)	(4,044.9)
Дүн	3,878.9	3,717.9	(161.0)

Эх сурвалж: Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 161.0 сая төгрөгөөр буурахад тайлант хугацааны үр дүн нөлөөлсөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсгийг ирүүлэхээр заасан.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн тайланд хамаарах тухайн жилийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийг нийт дүнгээр, хөтөлбөрөөр, төсвийн захирагчаар,

хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрээр, тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл, хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга, нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулгыг хавсаргаж ирүүлсэн байна.

3.5.1 Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төлөвлөлт

Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны төсвийн төсөлдөө зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 7,663.6 сая төгрөгөөр, үйл ажиллагааны орлогоос 50.0 сая төгрөгийг бүрдүүлэхээр тус тус тооцон санхүүжүүлэхээр төлөвлөж санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 14 арга хэмжээнд зориулан нийт 6,267.4 сая төгрөгийн төсөв баталсныг урсгал зардалд зарцуулахаар төлөвлөсөн байна. Нийт батлагдсан зардлын 98.1 хувь буюу 6,151.5 сая төгрөгийг улсын төсвөөс, үлдсэн 1.9 хувь буюу 115.9 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр тооцсон байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 5,702.6 сая төгрөгийн санхүүжилт олгогдож, үндсэн үйл ажиллагааны орлогоос 510.9 сая төгрөгийг бүрдүүлснээр тайлант оны орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 5,330.4 сая төгрөг буюу 85.0 хувьтай гарч, урсгал төсвөөс 488.1 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 8. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Хөтөлбөр	Зориулалт	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/сая төгрөгөөр/	
					Зөрүү	Биелэлт /хувь/
70201	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,202.8	847.0	355.8	70.0
	80218	Улс орноо гадаадад сурталчлах	65.8	65.8	0.0	100.0
	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	1.1	0.8	0.3	72.0
	81520	Олон улсын хурал, зөвлөгөөн	14.1	14.1	0.0	100.0
	81569	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	8.6	8.6	0.0	100.0
70418	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,934.1	1,893.1	41.0	98.0
	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	11.3	11.3	0.0	100.0
	81569	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	40.4	35.4	5.0	88.0
70410	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,984.2	1,895.0	89.2	96.0
	80215	Эрдэм шинжилгээ, судалгааны аж	20.0	19.5	0.5	98.0
	80226	Байр ашиглалтын үйлчилгээ	318.2	312.2	6.1	98.0
	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	16.5	14.7	1.8	89.0
	81569	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	632.7	195.3	437.4	31.0
	82313	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр	17.8	17.8	0.0	100.0
Нийт дүн			6,267.4	5,330.4	937.0	85.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Судалгааны үр дүн

Судалгааны үр дүн: Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу аудитын явцад тус байгууллагаас дараах зардлын судалгааг авч, үр дүнг дүгнэлээ. Үүнд:

Монгол Улсын Шадар сайдын харьяа байгууллагуудын цалин хөлс, орон тооны төлөвлөгөө, гүйцэтгэлд хийсэн судалгааны үр дүнгээс харахад батлагдсан төсөв, орон тоог бууруулан тодотгосон бөгөөд тайлант онд нийт 10 орон тоо дутуу ажилласнаас цалин хөлсний зардлаас 366.2 сая төгрөг хэмнэгдсэн байна.

Хүснэгт 9. Цалингийн зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөгөөр

Үзүүлэлт	Монополын эсрэг газар	Төрийн худалдан авах ажиллагааны газар	Хөрөнгө оруулалт, худалдааны газар	Нийт дүн
Анх батлагдсан орон тоо	36	54	30	120
Тодотгосон орон тоо	33	49	27	109
Орон тооны гүйцэтгэл	32	49	18	99
Орон тооны зөрүү	(1)	-	(9)	(10)
Анх батлагдсан цалингийн төсөв	1,440.0	1,623.0	935.1	3,998.1
Тодотгосон төсөв	1,424.1	1,532.8	846.3	3,803.3
Гүйцэтгэл	1,387.7	1,513.5	535.8	3,437.1
Хэтрэл/Хэмнэлт	(36.4)	(19.3)	(310.5)	(366.2)

Монополын эсрэг газар нь тайлант онд газрын даргын 2025 оны А/44 тоот тушаалаар ажлын нэг өдрийн хоолны нөхөх төлбөрийг 33.0 мянган төгрөгөөр, унааны нөхөх төлбөрийг 2.0 мянган төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоосон байна. Харин Хөрөнгө оруулалт, худалдааны газар нь 2024 оны А/38 дугаар тушаалаар ажлын нэг өдрийн хоолны нөхөх төлбөрийг 20.0 мянган төгрөгөөр, унааны нөхөх төлбөрийг 3.0 мянган төгрөгөөр, Төрийн худалдан авах ажиллагааны газар нь 2024 оны А/251 дугаар тушаалаар ажлын нэг өдрийн хоолны нөхөх төлбөрийг 22.0 мянган төгрөгөөр, унааны нөхөх төлбөрийг 3.0 мянган төгрөгөөр тус тус тогтоосон бөгөөд тайлант онд шинэчлэн тогтоогоогүй байна.

Хүснэгт 10. Унаа хоолны зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт/хэмнэлт
1	Монополын эсрэг газар	141.5	239.3	97.8
2	Төрийн худалдан авах ажиллагааны газар	183.4	228.3	44.9
3	Хөрөнгө оруулалт, худалдааны газар	65.4	80.6	15.2
Нийт дүн		390.3	548.1	157.9

Судалгааны дүнгээс харахад хоол, унааны зардал хэтэрсэн үзүүлэлттэй байгаа ч тус зардлыг цалин хөлсний хэмнэгдсэн зардлаас зарцуулсан байна.

Хөрөнгө оруулалт, худалдааны газрын тухайд гадаад албан томилолттой холбоотой 2 арга хэмжээнд 16.8 сая төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 2 арга хэмжээнд зарцуулсан бөгөөд аудитаар тушаал шийдвэргүй болон хууль тогтоомжид нийцээгүй зөрчил илрээгүй, бусад байгууллагуудын тухайд гадаад томилолттой холбоотой төсөв батлагдаагүй, гүйцэтгэл гараагүй байна.

Монгол Улсын Шадар сайдын харьяа байгууллагууд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй гэрээ байгуулаагүй, төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэхтэй холбоотой зардал гаргаагүй байна.

3.5.4 Тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл

Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2025 оны 01 дүгээр сарын 7-ны өдөр баталж, 2025 оны 8 дугаар сарын 18-ны өдөр тус төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж анх батлагдсан төлөвлөгөөний дүнг бууруулсан байна. Төсвийн ерөнхийлөн захирагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулав.

Хүснэгт 11. Худалдан авалтын төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөгөөр/

Нэр	Нийт дүн	Төлөвлөгөө			Нийт дүн	Гүйцэтгэл			Зөрүү	%
		Нээлттэй	Харьцуулалт	ШХА		Нээлттэй	Харьцуулалт	ШХА		
Монополын эсрэг газар	974.3	956.4	-	17.9	414.8	84.7	92.6	237.5	559.5	43
Хөрөнгө оруулалт, худалдааны газар	25.4	-	-	25.4	21.9	-	-	21.9	3.5	86
Төрийн худалдан авах ажиллагааны газар	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	999.7	956.4	-	43.3	436.7	84.7	92.6	259.4	563.0	44

Харьяа байгууллага /Монополын эсрэг газар/

Аудитын илрүүлэлт:

- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тайлант онд худалдан авах бараа, ажил, үйлчилгээг санхүүжилтийн эх үүсвэр, нэр төрөл, тендер шалгаруулалтын арга, төсөл, арга хэмжээ нэг бүрээр тусгаагүй бөөн дүнгээр нэгтгэж төлөвлөсөн, зарим төсөл, арга хэмжээг төлөвлөгөөнд тусгалгүйгээр худалдан авсан байна. Мөн тайлант онд худалдан авсан 59.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааны тайланд тусгаагүй, тайлагнаагүй байна.
- Тайлант онд ерөнхий гэрээний аргаар зохион байгуулах 52.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй бараа, үйлчилгээний техникийн тодорхойлолт, ажлын даалгавар, холбогдох бусад материалыг Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлээгүй, цахим дэлгүүрээс худалдан авалгүйгээр шууд гэрээ байгуулан худалдан авсан байна.
- Бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, өртгийн тооцоог боловсруулаагүй, зарим гэрээнд ерөнхий байдлаар тусгасан, мөн худалдан авсан бараа, ажил, үйлчилгээг хүлээн авсан комиссын акт болон гэрээ дүгнэсэн актыг гэрээнд заасан хугацаанд үйлдээгүй, худалдан авалтын гүйцэтгэл, гэрээний хэрэгжилтэд тавих хяналт сул байна.

3.5.5 Хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, хэрэгжилт

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар Монгол Улсын Шадар сайдын тайлант онд хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийг баталж, хөтөлбөрийн хүрэх үр дүнг хэмжих 3 шалгуур үзүүлэлт, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр 2 арга хэмжээ 100 хувийн, 1 арга хэмжээ 98 хувийн гүйцэтгэлтэйгээр тайлагнагдсан байна.

Мөн дээрх хөтөлбөр арга, хэмжээний хүрээнд 2025 онд Монгол Улсын Шадар сайдын төсвийн ерөнхийлөн захирагч тайлант онд 7 стратеги зорилтын хүрээнд 47 арга хэмжээ, үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг 96.5 хувийн гүйцэтгэлтэйгээр тайлагнасан байна.

Хүснэгт 12. Хөтөлбөр, арга хэмжээ

№	ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		Шалгуур үзүүлэлтүүд		Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Хувь
70410 Зах зээлийн өрсөлдөөн, хэрэглэгчийн эрхийн хамгаалалт							
20	20.1.1	Зах зээлийн шударга өрсөлдөөний таатай орчныг бүрдүүлсэн байна.	20.1.1.1	Зөрчил хянан шийдвэрлэлт	75.0	75.0	100%
	20.1.2	Хэрэглэгчийн эрхийг хамгаална.	20.1.2.1	Хэрэглэгчийн гомдлын шийдвэрлэлт	60.0	60.0	100%
	20.1.3	Худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулна.	20.1.3.1	Тендер шалгаруулалтын урилгыг цахим системд нийтэлсэн байх	99.0	96.6	98%

3.5.6 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх хүрээний байгууллагуудаас Монополын эсрэг газар орон нутгийн сонгуульд хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 9.8 сая төгрөгийн, Төрийн худалдан авах ажиллагааны газар үндсэн үйл ажиллагаанаас бий болсон 429.5 сая төгрөгийн нэмэлт орлогыг тус тус бүрдүүлж, нийт 439.3 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн байна. Уг эх үүсвэрээс 36.6 сая төгрөгийг зарцуулж, үлдсэн 402.7 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн төсвийн ерөнхийлөн захирагч түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад тавих дотоод хяналт болон төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн уялдааг сайжруулах, өр төлбөр үүсгэхгүй ажиллах, үндсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ, зах зээлийн үнийг холбогдох хууль, журам, стандартын шаардлагад нийцүүлэн шинэчлэн тогтоох, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийн ашиглалтын хугацааг шинэчлэн тогтоох, ашиглалтгүй болон цаашид ашиглах боломжгүй хөрөнгийг акталж данс бүртгэлээс хасах, хууль тогтоомж, журам, зааврын хэрэгжилтийг хангах, зөрчлийг давтан гаргахгүй байх, төсвийн захирагчийн хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлээр өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Э.Бат-Эрдэнэ гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер С.Нацагдорж, Тусгай чиг үүргийн газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Баярсайхан нар тус тус хэрэгжүүлсэн.

Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн ХЭГ/1084 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 6,106.3 сая сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 61.1 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

Ажлын баримтад материаллаг байдлын суурь үзүүлэлт, хувь хэмжээг сонгосон болон материаллаг байдлыг шинж чанарын хувьд авч үзэх шалтгаан, тайлбарыг тусгасан болно.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын төсөв захирагчид санхүүгийн сахилга батыг мөрдүүлэх, ил тод байдлыг нэмэгдүүлэх, үр ашгийг дээшлүүлэх, үрэлгэн зардлыг хязгаарлах, хяналтыг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд тайлант онд нийт 937.0 сая төгрөгийн зардлыг хэмнэсэн байна. Төсвийн хэмнэлтийн 43.8 хувь буюу 410.7 сая төгрөг нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын хэмнэлт, үлдсэн 55.9 хувь нь байр ашиглалт, хангамж, бараа материал, томилт, урсгал засвар, бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлын хэмнэлтээс бүрдэж байна.

Хүснэгт 13. Урсгал зардлын төсвийн хэмнэлт

/сая төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэмнэлт/хэтрэлт	Хувь
1	Монополын эсрэг газар	2,989.4	2,454.5	534.9	85.0
2	Хөрөнгө оруулалт, худалдааны газар	1,985.7	1,939.7	46.0	82.1
3	Төрийн худалдан авах ажиллагааны газар	1,292.3	936.2	356.1	97.6
	Нийт дүн	6,267.4	5,330.4	937.0	72.4

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 519.4 сая төгрөгийн 11 нийцлийн зөрчил илэрснээс, 251.7 сая төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага хүргүүлж, 267.7 сая төгрөгийн зөрчилд 5 зөвлөмжийг тус тус өгсөн.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитын илрүүлэлт:

Монополын эсрэг газар нь цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 47.0 сая төгрөгийн зарлагын 5 гүйлгээ, 5 сая төгрөгөөс дээш гэрээний дүнтэй нийт 156.5 сая төгрөгийн үнийн дүн бүхий 9 худалдан авалтын мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хуульд заасан хугацаанд үнэн зөв, иж бүрэн, ил тод мэдээлээгүй байна.

Түүвэрт хамрагдсан байгууллагууд

Илрүүлэлт: Хөрөнгө оруулалт, худалдааны газар нь тайлант оны батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хуульд заасан хугацаанаас хоцроож мэдээлсэн, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, 5 сая төгрөгөөс дээш гэрээний дүнтэй нийт 43.2 сая төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авалтыг мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хуульд заасан хугацаанд үнэн зөв, иж бүрэн, ил тод мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1.1 “тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор 6 дугаар зүйлийн 6.4.4 "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийн үнэн зөв иж бүрэн мэдээлнэ”, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 3.2.9 “таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээг гэрээ, хэлцэл, санхүүжилт өгснөөс хойш 7 хоногийн дотор энэ журмын 8 дугаар хавсралтад заасан маягтын дагуу цахимаар” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тогтоосон хугацаанд үнэн зөв мэдээлж байх зөвлөмж өгөв.

Илрүүлэлт: Төрийн худалдан авах ажиллагааны газар нь тайлант оны батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, хагас жилийн санхүүгийн тайлан, аудитын тайлан дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг хуульд заасан хугацаанаас хоцроож мэдээлсэн, 5 сая төгрөгөөс дээш гэрээний дүнтэй нийт 21.0 сая төгрөгийн үнийн дүн бүхий ажил, үйлчилгээний мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хуульд заасан хугацаанд үнэн зөв, иж бүрэн, ил тод мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.2.1 "эрх бүхий байгууллагаас баталсан жилийн төсөв, гүйцэтгэлийг хэмжих шалгуур үзүүлэлт", 6.3.3 "төсөв хэмнэсэн болон хэтэрсэн бол холбогдох шалтгааныг тайлбарласан тайлбар", 6.4 "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 3.2.9 "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээг гэрээ, хэлцэл, санхүүжилт өгснөөс хойш 7 хоногийн дотор энэ журмын 8 дугаар хавсралтад заасан маягтын дагуу цахимаар" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тогтоосон хугацаанд үнэн зөв мэдээлж байх зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төсвийн ерөнхийлөн захирагч

Илрүүлэлт-1: Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 519.4 сая төгрөгийн 10 нийцлийн зөрчил илэрснээс, 267.7 сая төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж, 251.7 сая төгрөгийн зөрчилд 5 албан шаардлагыг тус тус хүргүүлсэн нь өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчилтэй харьцуулахад материаллаг дүнгээр өссөн үзүүлэлттэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.36-д "төсвийн ерөнхийлөн захирагч гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг", 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 5.1.5-д "хариуцлагатай байх", 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 14.3-т "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна", 14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 5.1.5-д "хариуцлагатай байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих дотоод хяналт хангалтгүй байгаа зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

Аудитын илрүүлэлт:

Хууль, хяналт-шинжилгээ үнэлгээ дотоод хяналтын хэлтэс нь чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэх хяналт шалгалт хэрэгжүүлэх тухайн жилийн ажлын төлөвлөгөө боловсруулаагүй, хяналтын чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байгууллагын дотоод хяналт хангалтгүй байна.

Түүвэрт хамрагдсан байгууллагуудад илэрсэн нийцлийн зөрчил

Албан шаардлага

Илрүүлэлт-1: Хөрөнгө оруулалт, худалдааны газрын төсөв захирагч нь тайлант онд худалдан авах бараа, ажил, үйлчилгээг санхүүжилтийн эх үүсвэр, нэр төрөл, тендер шалгаруулалтын арга, төсөл, арга хэмжээ нэг бүрээр тусгаагүй бөөн дүнгээр нэгтгэж төлөвлөсөн, зарим төсөл, арга хэмжээг төлөвлөгөөнд тусгалгүйгээр худалдан авсан байна. Мөн тайлант онд худалдан авсан 99.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааны тайланд тусгаагүй, тайлагнаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-т "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", 44.2-т "Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд ерөнхий гэрээний аргаар худалдан авах бараа, үйлчилгээг тусгасан байна", 46 дугаар зүйлийн 46.1-д "Захиалагч худалдан авах ажиллагааны хэрэгжилт, үр дүнг тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан төсөл, арга хэмжээ бүрээр харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр тайлагнана", Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/250 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 2.2-т "Захиалагч төлөвлөгөөг батлагдсан нийт төсөвт үндэслэн төсөл, арга хэмжээ нэг бүрээр энэ журмын хавсралтын 1 дүгээр маягтын дагуу цахим системд боловсруулна", 2.11-т "Захиалагч цахим системд нийтэлсэн төлөвлөгөөг мөрдөж ажиллах ба энэ журмын 2.12-т заасан үндэслэлээр батлагдсан төлөвлөгөөнд орсон нэмэлт, өөрчлөлтийг холбогдох шийдвэр гарснаас хойш ажлын 10 өдөрт багтаан төлөвлөгөөнд өөрчлөлтийг тусган, батална. Хэрэв холбогдох дээд шатны байгууллага байгаа бол төлөвлөгөөний өөрчлөлтийг түүгээр батлуулахаар цахим системээр илгээж, өөрчлөлтийг баталгаажуулна", 2.19-т "Захиалагч тухайн жилийн төлөвлөгөөг энэ журамд заасны дагуу цахим системд бүрэн оруулж, батлуулаагүй нь хуульд заасан хариуцлага хүлээх үндэслэл болно", 3.11-т "Захиалагч тухайн жилийн худалдан авах ажиллагааны тайланг цахим системд бүрэн оруулж, батлуулаагүй нь хуульд заасан хариуцлага хүлээх үндэслэл байна" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд худалдан авах бараа, ажил, үйлчилгээг бөөн дүнгээр нэгтгэж төлөвлөсөн, зарим төсөл, арга хэмжээг төлөвлөгөөнд тусгалгүйгээр худалдан авч, тайлагнаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт-2: Хөрөнгө оруулалт, худалдааны газрын төсөв захирагч нь 41.1 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, өртгийн тооцоог нарийвчлан боловсруулахгүйгээр ерөнхий байдлаар боловсруулдаг нийтлэг зөрчилтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 24 дүгээр зүйлийн 24.6-д "Төсөв захирагчийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөх, гүйцэтгэлийн хяналт хийхдээ холбогдох норм, норматив, батлагдсан стандарт, зураг төсвийг үндэслэнэ", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан,

баталгаажуулах”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “Захиалагч техникийн тодорхойлолтод бараа, ажил, үйлчилгээний шаардлагатай гэж үзсэн шинж чанар, түүний зориулалт болон зориулалтын дагуу ашиглахтай холбоотой шаардлага, зураг төсөл, холбогдох стандарт, норм, дүрэм, зааврыг тусгана”, 12.2-т “Техникийн тодорхойлолтод бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд хэрэглэх түүхий эд, материал болон ажлын хүрээнд нийлүүлэх барааны шалгуур үзүүлэлтийг тодорхойлно” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, өртгийн тооцоог боловсруулаагүй, зарим төсөл, арга хэмжээг ерөнхий байдлаар боловсруулж байгаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Зөвлөмж

Илрүүлэлт-1: Төрийн худалдан авах ажиллагааны газрын даргын 2021 оны А/04 дүгээр тушаалаар Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталсан бөгөөд батлагдсан хугацаанаас хойш шинээр батлагдсан стандарт, хууль, журмын заалт, холбогдох өөрчлөлтийг тусгаагүй шинэчлэн найруулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2 "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах", 20.2.4 "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт шинээр батлагдсан стандарт, хууль, журмын заалт, холбогдох өөрчлөлтийг тусган шинэчлэх.

4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар нийт төсвийн ерөнхийлөн захирагч болон харьяа байгууллагын 82.8 сая төгрөгийн 14 зөрчил илэрснээс, 0.9 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 34.0 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 47.9 сая төгрөгийн зөрчилд 11 зөвлөмж өгснөөс төсвийн ерөнхийлөн захирагчид өгсөн 1 зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, бусад шийдвэрийн хэрэгжилт бүрэн хангагдсан байна.

Хүснэгт 14. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Нийт		Биелэлт /хувь/
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Монополын эсрэг газар	-	-	1	34.0	2	19.3	3	53.3	100
Хөрөнгө оруулалт, худалдааны газар	1	0.9	1	0	3	7.4	5	8.3	100
Төрийн худалдан авах ажиллагааны газар	-	-	-	-	4	21.2	4	21.2	100
Төсвийн ерөнхийлөн захирагч	-	-	-	-	2	-	2	-	50
Нийт дүн	1	0.9	2	34.0	11	47.9	14	82.8	87.5

Өмнөх оны аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжөөс хэрэгжилт хангалтгүй нэг зөвлөмжид албан шаардлага хүргүүлээ.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Засгийн газрын 2024 оны 251 дүгээр тогтоолоор Монополын эсрэг газар орон тооны 2 гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлж, шинээр гишүүдийг томилсон байна. Уг томилгоотой холбогдуулан гарсан маргааныг Захиргааны хэргийн дээд шүүх 2026 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр хянан хэлэлцэж, тухайн албан тушаалтныг өмнөх албан тушаалд нь эргүүлэн томилж, ажилгүй байсан хугацааны тэтгэмжийг нөхөн олгохоор шийдвэрлэсэн байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 235.9 сая төгрөгийн 8 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан.

Аудитаар нийт 231.8 сая төгрөгийн 10 зөрчил илэрснээс, 2.9 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 165.4 сая төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага хүргүүлж, 63.5 сая төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өглөө.

Аудитаар илэрсэн 231.8 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг түвшин 61.1 сая төгрөгөөс давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

5.1 Харьяа байгууллагууд

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 3 байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэснээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 2 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан. Аудитад хамрагдсан 1 байгууллагын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 231.8 сая төгрөгийн 7 зөрчил илэрснээс, 2.9 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 165.4 сая төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж, 63.5 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

5.2 Төсвийн ерөнхийлөн захирагч

Албан шаардлага

Илрүүлэлт-1: Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн удирдлага, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд хэрэгжүүлэх дотоод хяналт сул байгаагаас тайлант оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 231.8 сая төгрөгийн санхүүгийн зөрчил илэрсэн нь өмнөх оноос өссөн үзүүлэлттэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.36-д “төсвийн ерөнхийлөн захирагч гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг”, 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5.1.5-д “хариуцлагатай байх”, 14 дүгээр зүйлийн 14.2.3-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, 14.3-т “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна”, 14.2.10 “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, 69 дүгээр зүйлийн 69.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 5.1.5-д “хариуцлагатай байх” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад хэрэгжүүлэх дотоод хяналт хангалтгүй байгаа зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

Зөвлөмж

Илрүүлэлт-1: Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагууд төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан даруйд олон нийтэд мэдээлээгүй, сонгон шалгаруулалт явуулах тухай захиалгыг холбогдох байгууллагад хүргүүлэлгүйгээр сул орон тоонд тусгай шалгалт өгөөгүй нийт 9 албан хаагчийг түр орлон гүйцэтгэгчээр томилж, тайлант онд нийт 15.4 сая төгрөгийн улирлын үр дүгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2-т "төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх болон туслах албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас болон холбогдох бусад төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас", 27.2-т "Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан олон нийтэд мэдээлэх үүрэгтэй. Томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан сул орон тоо гарсан өдрөөс хойш энэ тухай мэдээллийг долоо хоногт, сонгон шалгаруулалт явуулах захиалгыг 21 хоногт багтаан төрийн албаны холбогдох шатны байгууллагад хүргүүлнэ", 42 дугаар зүйлийн 42.1-д "Хуульд өөрөөр заагаагүй бол эрх бүхий этгээд дараах тохиолдолд төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг төрийн жинхэнэ албан хаагчтай тохиролцсоны дагуу албан үүргийнх нь зэрэгцээ түр орлон гүйцэтгүүлж болно", Засгийн газрын 2023 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн 301 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх" журмын 1.1-д "Энэ журмын зорилго нь төрийн жинхэнэ албан хаагч (цаашид "албан хаагч" гэх)-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, тайлан гаргах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 1.2-т "Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн төрийн албан хаагчид дараах эрх бүхий албан тушаалтан мөнгөн урамшуулал олгоно", Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам"-ын 2-т "Албан үүргийг түр орлон гүйцэтгүүлсний цалин, урамшуулал" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудад дотоод хяналт хэрэгжүүлж, төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог тухай бүр олон нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг холбогдох журмын дагуу зохион байгуулж, тусгай шалгалт өгөөгүй этгээдийг түр орлон гүйцэтгэгчээр томилохгүй байх, мөн урамшууллыг хууль, журмын шаардлагад нийцүүлэн олгож байгаа эсэхэд хяналт хэрэгжүүлж ажиллах.

Илрүүлэлт-2: Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагууд нэг байранд байрладаг бөгөөд байр ашиглалтын төлбөрийг ялгаатай тарифаар төлдөг, мөн Төрийн худалдан авах ажиллагааны газрын байр ашиглалтын төсвийг өмнө нь байрлаж байсан байр ашиглалтын төсвөөр тооцож баталснаас тайлант онд 105.9 сая төгрөгийн өр төлбөр үүссэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 14 дүгээр зүйлийн 14.2 "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 14.2.5 "өөрийн агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах", 14.2.10 "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 69 дүгээр зүйлийн 69.1 "Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын байр ашиглалттай холбоотой төсвийн төлөвлөлтийг бодит нөхцөлд нийцүүлэн төлөвлөж, өр төлбөр үүсгэхгүй байхад анхаарч ажиллах.

5.3 Түүвэрт хамрагдсан байгууллага

Албан шаардлага

Илрүүлэлт-1: Хөрөнгө оруулалт, худалдааны газрын төсөв захирагч нь төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан даруйд олон нийтэд мэдээлээгүй, сонгон шалгаруулалт явуулах тухай захиалгыг холбогдох байгууллагад хүргүүлэлгүйгээр сул орон тоонд тусгай шалгалт өгөөгүй 2 албан хаагчийг түр орлон гүйцэтгэгчээр томилж, тайлант онд нийт 3.4 сая төгрөгийн улирлын үр дүнгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2-т "төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх болон туслах албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас болон холбогдох бусад төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас", 27.2-т "Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан олон нийтэд мэдээлэх үүрэгтэй. Томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан сул орон тоо гарсан өдрөөс хойш энэ тухай мэдээллийг долоо хоногт, сонгон шалгаруулалт явуулах захиалгыг 21 хоногт багтаан төрийн албаны холбогдох шатны байгууллагад хүргүүлнэ", 42 дугаар зүйлийн 42.1-д "Хуульд өөрөөр заагаагүй бол эрх бүхий этгээд дараах тохиолдолд төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг төрийн жинхэнэ албан хаагчтай тохиролцсоны дагуу албан үүргийнх нь зэрэгцээ түр орлон гүйцэтгүүлж болно", Засгийн газрын 2023 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн 301 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх" журмын 1.1-д "Энэ журмын зорилго нь төрийн жинхэнэ албан хаагч (цаашид "албан хаагч" гэх)-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, тайлан гаргах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 1.2-т "Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн төрийн албан хаагчид дараах эрх бүхий албан тушаалтан мөнгөн урамшуулал олгоно", Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам"-ын 2-т "Албан үүргийг түр орлон гүйцэтгүүлсний цалин, урамшуулал" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн жинхэнэ албан хаагчийн сул орон тоо гарсан даруйд олон нийтэд мэдээлдэггүй, сонгон шалгаруулалт явуулах тухай захиалгыг холбогдох байгууллагад хүргүүлдэггүй, төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоонд тусгай шалгалт өгөөгүй албан хаагчийг түр хугацаагаар томилж, улирлын үр дүнгийн урамшуулал олгож байгаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт-2: Төрийн худалдан авах ажиллагааны газрын төсөв захирагч нь төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан даруйд олон нийтэд мэдээлээгүй, сонгон шалгаруулалт явуулах тухай захиалгыг холбогдох байгууллагад хүргүүлэлгүйгээр сул орон тоонд тусгай шалгалт өгөөгүй 7 албан хаагчийг түр орлон гүйцэтгэгчээр томилж, тайлант онд нийт 12.0 сая төгрөгийн улирлын үр дүгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2-т "төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх болон туслах албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас болон холбогдох бусад төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас", 27.2-т "Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан олон нийтэд мэдээлэх үүрэгтэй. Томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан сул орон тоо гарсан өдрөөс хойш энэ тухай мэдээллийг долоо хоногт, сонгон шалгаруулалт явуулах захиалгыг 21 хоногт багтаан төрийн албаны холбогдох шатны байгууллагад хүргүүлнэ", 42 дугаар зүйлийн 42.1-д "Хуульд өөрөөр заагаагүй бол эрх бүхий этгээд дараах тохиолдолд төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг төрийн жинхэнэ албан хаагчтай тохиролцсоны дагуу албан үүргийнх нь зэрэгцээ түр орлон гүйцэтгүүлж болно", Засгийн газрын 2023 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн 301 дүгээр тогтоолоор

батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх" журмын 1.1-д "Энэ журмын зорилго нь төрийн жинхэнэ албан хаагч (цаашид "албан хаагч" гэх)-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, тайлан гаргах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 1.2-т "Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн төрийн албан хаагчид дараах эрх бүхий албан тушаалтан мөнгөн урамшуулал олгоно", Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам"-ын 2-т "Албан үүргийг түр орлон гүйцэтгүүлсний цалин, урамшуулал" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн жинхэнэ албан хаагчийн сул орон тоо гарсан даруйд олон нийтэд мэдээлдэггүй, сонгон шалгаруулалт явуулах тухай захиалгыг холбогдох байгууллагад хүргүүлдэггүй, төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоонд тусгай шалгалт өгөөгүй албан хаагчийг түр хугацаагаар томилж, улирлын үр дүнгийн урамшуулал олгож байгаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт-3: Төрийн худалдан авах ажиллагааны төсөв захирагч нь тайлант онд үндсэн үйл ажиллагааны орлогыг 115.9 сая төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны орлогод 510.8 сая төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансаар 429.5 сая төгрөг нийт 940.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж, үүнээс 759.7 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн бөгөөд орлогын бүртгэл, хяналт, тайлагналын тогтолцоо хангалтгүй байгаагаас дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- Үндсэн үйл ажиллагааны орлогыг бодитой, үндэслэлтэй төлөвлөж, батлуулаагүйгээс гүйцэтгэл төлөвлөсөн хэмжээнээс давсан;
- Байгууллагын үйлчилгээний хураамжийн орлого төвлөрүүлдэг Голомт банкны 8340126100009 дугаар дансны тухайн жилийн орлого, зарлагын гүйлгээ, эхний болон эцсийн үлдэгдлийг баталгаажуулаагүй, тус дансны мэдээллийг зөвхөн төсөв захирагч гүйлгээ хийж, танилцах эрхтэй;
- Үйлчилгээний хураамжийн дансанд төвлөрсөн орлогыг хуваарилах үйл явц системжээгүй;
- Үйлчилгээний хураамжийн 12 дугаар сарын орлого 101.0 сая төгрөгийг тайлант онд бүрэн төвлөрүүлээгүй;
- Үйлчилгээний хураамжийн орлоготой холбоотой анхан шатны баримтын бүрдэл, тооцоолол хангалтгүй, нягтлан бодогчийн хяналт сул;
- Тайлант онд үйлчилгээний хураамжийн орлоготой холбоотой 60,845 ширхэг и-баримтыг нэг бүрчлэн гараар шивж бүртгэж байгаа нь бүртгэлийн алдаа гарах, дүн зөрүүтэй илэрхийлэгдэх, нягтлан бодогчийн ажлын ачаалал нэмэгдэх зэрэг санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдэлийг бий болгож байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.5. бүх орлого, 20 дугаар зүйлийн 20.1.1-д "нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах", 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 6 дугаар зүйлийн 6.3.4-т "төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх", 7 дугаар зүйлийн 7.7-д "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн

төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үйл ажиллагааны орлогыг бодитой, үндэслэлтэй төлөвлөөгүй, тухайн жилийн орлого, зарлагын гүйлгээ, дансны эхний болон эцсийн үлдэгдлийг баталгаажуулаагүй, орлогын хуваарилалтыг системжүүлээгүй, орлогыг тайлант онд багтаан бүрэн төвлөрүүлээгүй, анхан шатны баримтын бүрдэл, тооцоолол хангалтгүй, нягтлан бодогчийн бүртгэлд хэрэгжүүлэх хяналт хангалтгүй, и-баримтыг нэг бүрчлэн гараар шивж бүртгэдэг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Монополын эсрэг газар	6	227.8	1	5.0	5	222.8	6	227.8	-	-	-	-
Хөрөнгө оруулалт, худалдааны газар	2	8.1	1	4.0	1	4.1	2	8.1	-	-	-	-
Дүн	8	235.9	2	9.0	6	226.9	8	235.9	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Монополын эсрэг газар	4	216.4	1	2.9	1	150.0	2	63.5
Хөрөнгө оруулалт худалдааны газар	1	3.4	-	-	1	3.4	-	-
Төрийн худалдан авах ажиллагааны газар	2	12.0	-	-	2	12.0	-	-
Монгол Улсын Шадар сайд	3	-	-	-	1	-	2	-
Дүн	10	231.8	1	2.9	5	165.4	4	63.5

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Монополын эсрэг газар	1	203.5	-	-	1	203.5
Хөрөнгө оруулалт худалдааны газар	1	43.2	-	-	1	43.2
Төрийн худалдан авах ажиллагааны газар	1	21.0	-	-	1	21.0
Дүн	3	267.7	-	-	3	267.7
Бусад хууль тогтоомжийн зөрчил						
Монополын эсрэг газар	4	111.6	3	111.6	1	-
Хөрөнгө оруулалт худалдааны газар	2	140.1	2	140.1	-	-
Төрийн худалдан авах ажиллагааны газар	1	-	-	-	1	-
Монгол Улсын Шадар сайд	1	-	1	-	-	-
Дүн	8	251.7	6	251.7	2	-
Нийт дүн	11	519.4	6	251.7	5	267.7



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1458/АДМ1371

Улаанбаатар хот

САГ-2026/13/НА-СТА-ТЕЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Харьяа байгууллагуудын хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байгаагаас санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудлаар 619,390,625.00 /таван зуун арван есөн сая гурван зуун ерэн мянга зургаан зуун хорин тав/ төгрөгийн зөрчил илэрсэн нь өмнөх оноос өссөн үзүүлэлттэй байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.36-д “төсвийн ерөнхийлөн захирагч гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг”, 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5.1.5-д “хариуцлагатай байх”, 14 дүгээр зүйлийн 14.2.3-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, 14.3-т “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна”, 14.2.10-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 5.1.5-д “хариуцлагатай байх” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих дотоод хяналт хангалтгүй байгаа зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд /Т.Доржханд/, Ерөнхий нягтлан бодогч /Д.Гантуяа/, Ахлах шинжээч /Н.Найданболд/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



С.МАГНАЙСҮРЭН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1459/АД111371

Улаанбаатар хот

САГ-2026/13/НА-СТА-ТЕЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн удирдлага, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд хэрэгжүүлэх дотоод хяналт сул байгаагаас тайлант, оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 231,787,886.00 /хоёр зуун гучин нэгэн сая долоон зуун наян долоон мянга найман зуун наян зургаа/ төгрөгийн санхүүгийн зөрчил илэрсэн нь өмнөх оноос өссөн үзүүлэлттэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.36-д “төсвийн ерөнхийлөн захирагч гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг”, 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5.1.5-д “хариуцлагатай байх”, 14 дүгээр зүйлийн 14.2.3-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, 14.3-т “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна”, 14.2.10 “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, 69 дүгээр зүйлийн 69.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 5.1.5-д “хариуцлагатай байх” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0424 SAG-50.Docx

1526182370

1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад хэрэгжүүлэх дотоод хяналт хангалтгүй байгаа зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд /Т.Доржханд/, Ерөнхий нягтлан бодогч /Д.Гантуяа/, Ахлах шинжээч /Н.Найданболд/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

